1,

07422

## Дунчүүр маань

Нэгэн зуун боди садува
Нэгэн зуун бурхан бэ
Нэгэн зуун нэг мянга
Арьяа бала нума тэ
Бадма нирдү лочи шари
Үй хум маань бад ми хум 3

### Чагаан шүхэртийн оршил

Энэтхэгийн хэлээр: Арьяа дата гада ушнаха сидхада
намо дарани
Төвдийн хэлээр: Пагва дэшин шэгвий жугдор нар
жун вай дуг гарбожан шанжуш митувба
чир дагва чэнмо чогдү дувба шэй жа вийсүн
Монгол хэлээр: хутагт түүнчлэн ирсэний үснээс
гарсан „цагаан гүүхэрт бусдад үл ялагдах
их хариулагч дээд ~~гаржан~~ бүтээж нэрт
судар оршвой„
“Тову хамчү нагва нэрт судар оршивой„
Наму буддахаяа намо дхармаяа Намо сангхаяа
Э-ийн хэлээр Базар маха додха раза
Т-ийн хэлээр Дорж Товий жамбой чэндо хамчү нагво догвий
Монгол хэлээр: Их эрхт хилэгнэсэн очир хар хэл амь(сүн)тар-
(шилаг)
Хилэгнэгсдийн хаан хүргэгсдийн чуулганаа мөргөмүй!
Ум Базар маха додха бадам додха шори базар ги ма.ги
ма.гий маха ягмаа га ла ру ба гарма рам рам зу ла
рам рам хум хум пад пад. хорт дайсан тотгор хум пад
Намо ламын үнэн зарлиг хийгээд бурханы үнэн зарлиг
номын үнэн зарлиг, бурхан хувраггуудын үнэн зарлиг.
Ялж төгс нөгчсөн Манзушир(ий)н олон(ы) чуулганы үнэн
зарлиг Бадам зориг(и)йн чуулганы үнэн зарлиг
Сэтгэлийг — тэнгэр нарын чиг — 1 — 11 — 11 —
Эрдэнэт рашааны тэнгэр нарын — 1 — 1 — 11 —
Хачуу үйлсийн тэнгэр — 1 — 11 — 11 — 11 —
Эх зардсан тэнгэр — 11 — 11 — 11 — 11
Ухааныг дариг лам эрдэнийн чуулганы тэнгэр
нарын — 1 — 1

Ертөнц дахь тахил шүтээний тэнгэр наршн чуулганы үнэн зарлиг
засан эрхэн тусын
Их үнэний адистэдийн хүчээр бидэн ба бүрэн нөхөр сэлт
үнэн тахил өгөгч хийгээд дор өштөн дайсны хүчийг эвдэтүгэй
Тотгор нүгүүдийн хүчнийг эвдүтүгэй! Шимнусын хүчнийг дартугай!
Хортон дайсны тотгорын ам хэлийг хамаг тацилсыг харигулугтугай!
Муу зүүдэн хийгээд муу ёр хамаг бэлгийг харигулугтугай!
Ум найман овгийн шандан гуру яа хи дум
Гурван орон васан гуру яа сува яа Дөрвөн тивийн хэл
ам хов өшөөлөх хүмүүсийн хэл, дайсны хорлол
дайсны ам одоогийн төрийнхний үхэл ад үл зохилдохуйн
зүг бүрд шившлэх болтугай! Шандан гуру яа сува яа
Гэнэт бусдын ам хэлийг мара яа бад гуру яа сува хэл
хэлнээс ялах болтугай! Бас дум гуру яа хар хэл амыг
харигулугтугай!
Адистэдийн эрхэм лам гурван эрдэнэ, Аугаа их буян билгийн
бэлгэ Асар гэгээнтний рашаан номын зарлиг ариун
сэтгэлээр аврагч ламд мөргөмүй
Хамаг бурхан нууцын очир богд Ямандага хагацал үгүй
номын чанар Ямандага Хамаг итгэл Эхрагуудын
чанар Ямандага хайрлан соёрхогч Ямандага чам
дор мөргөмүй! Хүчний эрхэт дөрвөн үйлсийн ~~хүчээр~~
хүслээр нэгэнт дуусгасанаар биеийн зовлонг арилгаад
хүмүүлэг хагацалгүй санг өгөгч хүнд итгэл зургаан
гартад мөргөмүй! Энэ мэтчилэн буян билгийн
хүчинд эрхэн багш шавь, хорших хүүхдүүдийн эмгэг,
зовлон өвчин арилтугай! Эрхэм хүслээр зүгээр бурханы
хутаг дор хүрэх болтугай!
Гунга балам гүүш дуурьдсанаар эрдэмт богд далай ламын
Очирт хааны айлтгаж Агваан гүүш орчуулаад ус
тогтсон бичиг Ямандагийн сүм наймуулсны бичээс
Абтай сайн буян орвиттугай
Ум сайн амгалан болтугай!

# Сонгоодсын хөтөлбөр

Бодь мөрийг олох эрхэт судар оршивой

Лам гурван эрдэнэд мөргөмүй.

Хүн энэ насандаа ямагт буян үйлдээч гэсэн үхэх
цагтаа нүгэлтэй сэтгэж үүсгэж үхвээс муу заяанд
төрнө. Энэ насандаа ямагт нүгэл үйлдсэнч үхэх
цагтаа буянтай сэтгэл үүсгэвээс амар заяанд төрнө
хэмээн номлосон тул үхэх цагт, маш хайрлах эд товар
хөвгүүн төрлийн зэрэг тачаах зүйл, өст дайсан зэрэг
л үүсгэх зүйлийг сонсох үгүй сэтгэлийг цайруулах үгүй
агуулж өрөөл өөрийн өчүүхэн сүсэгтэй лам бурханы
нэгийг оруулан тодхон санаж түүнийг лам бурхан бүгд
миний эрөөл гүйцэтгэгчийн хураангуй мөн хэмээн
санаж үүнд намайг энэ хойтын зуурдын айдас зов-
лонгоос аварч Гандан жанцид Дэвааженгийн оронд
даруй хөтлөн соёрх. хэмээн залбирч гүйцэж товаан
бурхан, оточ бурханы нэр зэргийг мэдэж лам бурханы
хөрөг байвал дэлгэж тахил өргүүлнэ. Адистэдтэй
үрэл байвал хүртэнэ. Тогоо байвал амьсгал хураах
цагт эрэн нүхний тус газарт түрхүүлнэ. Хэрэв
үхэх цагт зовлон их эрэмбэх амины урсгын
үйлдсэн буян түүгүй боловуу хэмээн муу заяанд
төрөх болуу гэж битгий сэтгэж энэ нь харин
нүглийн үр энэ биенд эдэлж дуусвал хойд төрөлд
Гандан жанцид Дэвааженгийн оронд төрүүлэхийг
шавдан залбирвал. Тэр цагт идээ ундаа. халуун,
хүйтний хүсвээс харин гандан жанцид Дэвааженгий-
ний оронд идээ ундаа хүрсэн мэт санаж! Нүгэлт
сэтгэлийг үүсгэж жий баруун хажуугаар гүйх тул
дарж хөвөнгөөр бөглөүл сайн! анх бие суларч
газарт чивэх мэт болж, сэтгэл дүр усны зэрэглээ
мэт жөх өнгө ургавал шороон махбод хураасны
тэмдэг. Тэр цагт зүүн зүгээс Доржсамбуу хэмээх
бурхан бие нь үүлийн чинээ олон бодисадвагаар хүрээ-
лүүлж ирэх тул сэтгэлийг зүүн зүг харж. Түүнд
айдас үгүй. сүжиглэж намайг гандан жанцид
Дэвааженгийн оронд төрүүлэх амьтаныг түсгэлмүй
хэмээн залбирмуй! Үүний сүүлд ам хамар хатаж
уруул шазайж бөгжийж утаа айсах түгэх мэт
боловоос усан махбод хураасны тэмдэг. Тэр

цагт өмнө зүгээс Рэднаасамбуу хэмээх бурхан
нөхөд савт урьдын адил ирэх тул сэтгэлийг өмнө
зүгт харж урьдын адил залбирна. Түүний сүүлд
бөхсөнөөс зүрхэн дүр хүртэл хураах! сэтгэл дүр
огторгуйд галын очоор дүүрэх мэт болвоос гал
махбодь хураасны тэмдэг! Тэр цагт баруун зүгээс
Аюуш Авид бурхан урьдын адил ирэхэд сэтгэлийг баруун
зүг харж урьдын адил залбирна. Үүний сүүлд амьсгал
давхцаж дотоод амьсгаа хүчтэй татаж бөглөөд хэрчиг-
нэх дуун гарах сүүл дор урьд мэт гал унтаж хэтэн
хүйтэн сэлмэрсээр амьсгал тасарч сэтгэл зул
бадарч салхигүй хөдлөхгүй мэт унтаваас энэ нь
Хий махбодь хураасны тэмдэг энэ үед хойд зүгээс
Амагсид бурхан урьд мэт ирэхэд сэтгэлийг хойд зүг
харж урьдын адил бас залбирна! Энэ нь гадаад амьс-
гал тасарч Сэтгэл огторгуй мэт хоосон төөрөлгүй байна
үүний дараагаар сэтгэлд тунгалаг огторгуйд сарны
гэрэл тусэх мэт цагаан зам, Наран ургах мэт
улаан зам. Үдшийн бүлээр харанхуй мэт хар зам
ургаж үүний сүүлд намар үүр цайх мэт хоосон ог-
торгуйн агаар мэт ургаж нөгөө үхэхийн тэмдэг тул эдгээр
амьсгал хураахаас эхлэн үхэх хүртэл лам бурханд
урьдын адил залбирч юм үзэгдэж төрсөөс цөм зүүд
шиг мэт хоосон чанар болов хэмээн хоосон чанарыг
бясалгана. Түүний сүүлд Хаана төрөх зуурдын төрлийг
авна. Зуурдын бие болвоос төрөх толбороггүй санасан
төдийд тэр газарт хүрэх саадгүй. Нар сар үзэгдэхгүй урьд
насны ах дүү, хөвгүүн төрлийн буян юу хийж байгааг
бүгдийг үзэж мэдэх болов ч тэдэнтэй ярьж болохгүй
тул Эдгээр Ийнхүү зуурдад төрөхийг айсгалаас мэдээд
зуурдад буян нүгэлийн санаагаар сайн муу нэг хэлбэр
гарахын тулд тэр цагт нүгэлт сэтгэл үүсгэхгүй урьдын
сүжигт лам бурханыг дуудаж урьд мэт хичээж залбирмуй!
Тэнгэр хүн адгуус хаа төрөх болвоос түүний дүрстэй зуурдад
төрөхийн дээр хаа явах газараа бадаг гэрэл мэт цагаан
зам ургаваас тэнгэр асури нар. ногоон. хүн шар, бор улаан
адгуус хар. тамын утааны өнгө үзэгдэх болой бас толгой
дээш, хөндлөн, доош харвал амин болов ч тэр нь:
урьдын чөлөө мөн хэмээн нэмсэн тул эдгээр бүхэн
ажиглан мэдэж урьд мэт лам бурханыг дуудаж

5,

Бас зүүдэнд их үүл нурах, дарах зэрэг далай хямрах,
ой цэцэрлэг түлэгдэх, салхи хийсгэх ба айх мэт эрлэгүүд
элдэв мэс далайж айлгах, ураг төрөл садан болж
худал дуудах, ад чөтгөр, бурхан мэт хувилан хуурч
буруу мөр заах зэргийн элдэв айх, баярлах, дүрс
дуун үзэгдэх, сонсогдох эндүүрэл болох юм үзэгдвэл
баярлаж айхгүй зүүд илбэ мэт хоосон үзэгдэл
болгон санаж лам бурханы хувилгаан болгон
сүжиглэж урьд мэт Гандан Хаанд Дэвааченийн
оронд төрүүлж амьтныг туслахын тулд Бурханыг
хутаг олохыг үргэлж шамдан залбирна. Үүнээс
дээш зүйлүүдийг одоогоос дахин. дахин санаж чөр
цагт ингэж залбирна. Тийм тэгж залбирахыг
лам бурхан аварна гэж залбирч сэтгэлдээ гэнэлдүүлээд
үхэх цагт айхгүй, хөвгүүн эцгийнхээ гэрт очих мэт
түргэн бясалгах хэрэгтэй гэжээ. Хэрэв өвчин хатуу ба
үхлийн эрхээр энэ зүйлийн тухай санаж эс чадваас.
хүнээр тухай тухайн үесийг тохиолдуулан дуудуул-
ваас мэдэж болно. Хамгийн номлосон үүнийг
мэргэдийн номлолын товчлон хураан амьтанд тус
болох боловуу гэж бичвээ. (Ум ма ни бад мэ хум)
(Ум базар саду сумъяа мануулаая базарсаду дэнвва
дэста дэрдоо мэ ба судхэй мэ ба сүүхэй мэ ба сарваа
сэдий мэ барий ядаа сарваа гармаа судзаа мэ зэуэм
шарий гуруу хам хаа хаа хаа хаа. Худ багаа сарваан
датаа гадаа базар мамэ мунзаавваа маха сумъяа
саданаа хум пад (буруу бол аваас базар гадаар ариугуттагу)
Өлзий хутаг бат орших болтугай! Ум ма ни бад ма хум

| | | |
|---|---|---|
| Могой Морь жилд | Урд зүгээс | гал |
| Хонь жилд | Баруун урдаас | шороо |
| Мич тахиа жилд | Баруунаас | төмөр |
| Нохой жилд | Баруун хойноос | [illegible] |
| Гахай Хулгана | Хойд | ус |
| Үхэр | Зүүн хойноос | уум |
| Бар туулай | Зүүнээс | мод |
| Луу жилд | Зүүн урдаас | хий |

Түс түс хар Нохойн ам хариа
2002 онд Урд зүгээс

